

ЧОЙ ЛА ЖАВ СУ ЧИЙ-НОМЫН АВРАЛД ИТГЭЕ SCIENTIFIC OPINION



Д.Нямдорж. ХСИС-ийн Шинжлэх ухаан, технологийн газрын Хил судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, цэргийн ухааны доктор, профессор, хурандаа
Nyamdorj.Ts. Senior researcher of Limnology Center, Science and technology department, Law Enforcement University, Professor, Ph.D, colonel

Abstract: Book can learn discernment four. Memorize the letter and find the common values and feel the hidden meaning, it is vital to understand the meaning. True enlightenment as vital to find the value of the library. The "essential values necessary to train your heart."

Номонд шамдахад ойлгоцын дөрвөн хэлбэр байдаг. Энэ нь үсэгчлэн чээжлэх, ерөнхий утгыг олох, далд утгыг мэдрэх, амин утгыг ойлгох болой. Жинхэнэ гэгээрэлд хүрэх гэвэл номын амин утгыг олох хэрэгтэй. Тэрхүү "амин утгыг сэтгэлдээ дадуулах" шаардлагатай.

"Дээдийн шидэд хүрэх гэж бий. Тэр нь үндсэндээ гэгээрч байгаа нь юм. Хэн ч бидний өмнөөс гэгээрэлд хүрэхгүй, хэн ч гэгээрлийг бидэнд өгөхгүй, номыг хүртэж өөрийн сэтгэлийн урсгалд агуулсан нэгэнд л гэгээрэл ирэх нь магадтай. Номыг тогтон сууж, уншин бясалгаснаар бидний амьдрал түүнтэй нэг болж, үтэр түргэн гэгээрэлд хүрэх боломжтой болно, авралыг өөрийн дотоод мөн чанараасаа хай" гэж Дээрхийн Гэгээнтэн 14 дүгээр Далай лам айлджээ. Хэзээ ном уншдаг, номонд сүслэдэг, **авралыг** (ажил сайжруулах аргыг) номноос хайдаг болцгоох вэ? Номтой нөхөрлөж байж л, "юм" (мэдлэг)-тай болдог гэж мэргэд айлддаг сан.

Амьдрал баян. Ингэнэ, тэгнэ гэсэн бэлэн жор байхгүйгээс хойш ажлыг сайжруулах аргыг, амжилтанд хүргэх нууцыг ном, сэтгүүл уншиж хайна, юм юм сонсож хайна. Ахмадаасаа асууж хайна, анд нөхөдтэйгээ маргаж хайна, ажлынхантайгаа зөвлөж хайна. Эцэс төгсгөлгүй эрэлд хатаж, энд тэндгүй хайна, сурал болж, эрэл хийхэд ном тусална.

Та өөрийнхөө төлөө 100 хувь хариуцлага хүлээн гэдэг бол бүх буруутай эзэн та өөрөө гэдгийг хүлээн зөвшөөрөхөд хамаг учир байдаг аж. Амьдралынхаа бүх үйлдлийн эзэн шалтгаан нь зөвхөн өөрөө гэдгийг хүлээн зөвшөөрч байж, өөрийн хүсэл мөрөөдлийг

биелүүлэхийн төлөө өөрөө ухамсартайгаар зүтгэж чаддаг гэнэ.

Ном бол нүүр харж, тал засдаггүй, ачилж аварсныхаа шанг горьддоггүй, үнэгүй туслагч, үнэнч зөвлөгч. **"Ухаантай хүнд зөвлөгөө хэрэггүй, тэнэг хүнд бүр ч хэрэггүй. Тэнэгүүд түүнийг хэзээ ч хэрэглэдэггүй"** гэж "Амьдралын алтан ном"-д бичиж **"Хүмүүс зан авираа засаж сайжруулахгүй, сургаж хэлээд байгаа юмыг ойлгохгүй, бас үүргээ мэдэж буй атлаа түүнээ биелүүлж, гэм согоогоо хаяж гээх чадваргүйг хараад би гасалж ганихрах юм даа"** гэж Кунз сургаж.

Огт байхгүй юманд итгэх нь төөрөгдөл мөн. Харин мэдрэхгүй, ойлгож хүчрэхгүй байгаа болгоноо огт байхгүй мэтээр няцаах нь түүнээс дутахгүй төөрөгдөл мөн. Хүн, аливаа хүндрэл, бэрхшээл зовлонгийн учир шалтгааныг өөрөөсөө эрэх дургүй амьтан. Ер нь миний бяргүйгээс, хурдан гүйж чаддаггүйгээс, хувийн сэрэмж дутсанаас ингэлээ гэж гунихын оронд, онгон модны мөчир хугалсан, тахил шүтээнийг гомдоосон зэрэг хөндлөнгийн учир шалтгаантай хэмээн үзэх нь хамаагүй хялбар аж.

Түүнчлэн модонд очиж мөргөөд асуудлыг шийдэх нь өөрөө хурдан гүйдэг болох, огт заяагаагүй овсгоо самбааг эзэмшихээс хямд төсөр ажээ. Хүн чадал мөхөсдөхийн хэрээр сүсэглэх хэрэгцээ гарна. Үүнийг өрнөдийн мэргэд **"бодит боломж багасахын хэрээр хий горьдлого ихэснэ"** хэмээн томъёолсон удаатай.

Танин мэдэх үйл ажиллагааны үр дүнд хүний эзэмших үйлийн баримжааг тодорхойлох тухайн судлагдахуун болон ур ухааны нэгдлийн тогтолцоог

мэдлэг гэдэг байна. Өнөө бид, хувь хүний хувьд мэдлэгтэй мэдээлэлтэй **хүн**, шүтээний хувьд **мэдлэг**, хувирах нөөцийн хувьд **оюун ухааны нөөц**, хөгжлийн шатны хувьд **оюуны технологийн хөгжлийн эрчимжилтийн шатандаа орох** үед амьдарч байна.

Юм уншилгүй мэдлэг хуримтлуулсан, ном шүтэлгүй эрдэмд **гэгээрсэн** бодгаль одоохондоо гараагүй байна. Ном бол шагналд өгдөг халуун сав, баярын бичиг, хэдэн халтар төгрөгний аль аль нь ч биш, харин сайн хүмүүсээ **шагнаж урамшуулмаар үнэтэй цайтай эд**. Манайхан "юмхан"-аар шагнаад, номоор шагнадаггүй нь сонин. Эндээс л номонд хандах хандлага нь харагдаад байгаа юм.

Сурсан болж хуурамбууд, дипломын булангаас зуурамбуудад л хэрэггүй байдаг юм уу гэхээс биш, ном бол манай залуус бие биенээсээ эрж сураад, урьтаж унших гэж уралдаж давхиад, тэртээ холоос тэн тэнгээр нь тээж ирээд хүртэж суумаар эрдмийн охь, эрднийн шижир л юм шүү дээ...

...Миний өмнө хилийн нэгэн отрядын 2013 оны эхний 10 сараар авсан офицер, ахлагч, энгийн ажилчдын уншсан номын жагсаалт байна.

Нийт 47 уншигч давхардсан тоогоор 176 ном уншсаныг дундажлавал нэг хүн ойролцоогоор 4 ном уншсан нь энэ жагсаалтаас харагдана. Эдгээр 47 хүний нэг нь 10 сарын дотор 26 ном уншсан нь анхаарал татах агаад, Хил хамгаалах байгууллагын хэмжээнд хэд дүгээр байранд орох бол гэж бодохоор... уралдуулаад үзмээр, урамтай санагдана...

Энэ отряд яах аргагүй, ХХЕГ-ын удирдлагын өгсөн **"хүнээ хөгжүүлэх"** үүргээ биелүүлж, хүмүүсээ гэгээрэл өөд хөтлөж яваа, хүмүүсийнхээ сэтгэлийг хөглөж байгаа отряд мөн харагдана.

Хүн байхын тулд гурван тэнхээтэй байх ёстой гэдэг. Нэгдүгээрт, сэтгэлийн тэнхээтэй; хоёрдугаарт, биеийн тэнхээтэй; гуравдугаарт, мэдлэгийн тэнхээтэй байх ёстой байнам.

Дэлхийн болоод манай сонгодгууд **"...ганцхан бурхан буй тэр бол мэдлэг"** (Сократ) хэмээгээд, **"Баяжихыг бус боловсорч гэгээрэхийг хичээ. Эд баялаг амархан, үрэн таран болно, эрдэм ухаан хэзээ ч үрэгдэж алга болдоггүй"** (Эзоп) **"Үзэх, мэдрэх гэгч нь орших гэсэн, сэтгэх, хөдөлмөрлөх гэгч амьдрах гэсэн үг"** (Виллиан Шекспир), **"Мэднэ, сурна гэдэг ялна, дийлнэ гэсэн хэрэг"** (А.Несмеянов) үүний тулд, **"Зун цагийн болжмор мэт эрт босож бай. Хүмүүний амьдрал гэдэг, өвлийн өдөр шиг богинохон"** (М.Шагдарсүрэн) гэжээ.

"Мэдэж, сурах"-ын эрэлд мордогсдын, эдэлж болохгүй эрх нь **"залхуурал"** агаад, **"Залхуу бол цаг хугацаагаар өл залгагч адгуус"** (А.Декурсель), **"Залхуу бол бие, сэтгэлийг царцаан хөлдөөгч"** (В.Белинский), **"Залхуу бол ухаан бодол, бие махбодийг гэмтээгч зэв"** (М.Монтень), **"Залхуурал бол хэн бүхэнтэй хялбархан эвлэрдэг**

дайсан" (Ф.Ларошфуко), **"Залхууран зүгээр суугч бол, зүүгүй цагтай адил"** (Ф.Купер), **"Залхуурч суух нь, аз жаргалаасаа зугтаж байгаа хэрэг"** (М.Достоевский) болохоор залхууралтай заавал тэмцэж, ямарч нөхцөлд ялан дийлэх хэрэгтэй болох нь.

Номонд шамдахад ойлгоцын дөрвөн хэлбэр байдаг. Энэ нь үсэгчлэн чээжлэх, ерөнхий утгыг олох, далд утгыг мэдрэх, амин утгыг ойлгох болой. Жинхэнэ гэгээрэлд хүрэх гэвэл номын амин утгыг олох хэрэгтэй. Тэрхүү **"амин утгыг сэтгэлдээ дадуулах"** шаардлагатай.

"Сайн номыг унших нь саруул ухаант хүнтэй ярилцах адил" (Н.Толстой) агаад, **"Хүнийг нөхөрлөж буй нөхрөөр нь танихын адил, уншиж буй номоор нь таньж болдог"** (С.Смайлс) болохоор, **"Надад байгаа сайн сайхан бүхэн номын ач"** (М.Горький), **"Номын ачаар бидний дотоод сэтгэлийн ертөнц нээгдэж, хорвоо ертөнцийг танин мэдэх бял суудаг"** (С.Цвейг)-аас, **"Номын ертөнцөд умбахдаа бид хорвоогийн хаад ноёдын чуулганаас илүү баяр хөөрийг эдэлдэг"** (Бокачо) байнам.

Ертөнцийн гурван цагааны нэг: **"өөдлөхөд номын мөр цагаан"**, гурван харанхуйн нэг: **"номгүй хүний тархи харанхуй"**, гурван хайраны нэг: **"уншиж сураагүйд ном хайран"**, гурван чимэгийн нэг: **"сайхан ном ухааны чимэг"**, гурван сайхны нэг: **"эргүүлж уншихад ном сайхан"**, гурван тусын нэг: **"төөрөлдөж явахад номын тус"**, гурван шившгийн нэг **"унших дургүй хүнийг, сонсох хүртэл шившиг"**, гурван бүтний нэг: **"уншиж судалдгийн ухаан бүтэн"**, гурван тэнэгийн нэг: **"эрхэм тэнэг номоо магтана"**, гурван холын нэг: **"уншдаггүй хүнд ном хол"**, гурван бугийн нэг: **"номгүй оюутан сургуулийн буг"**, гурван давхрагын нэг: **"өргөн мэдлэг номын давхаргатай"**, гурван ханийн нэг: **"оюутан хүнд ном хань"**, гурван нууцын нэг: **"уншаагүй номын утга нууц"**, гурван баяны нэг: **"эрдэмтэй хүний толгой баян"**, гурван хоосны нэг: **"номгүй хүний толгой хоосон"**, гурван хөөрхийн нэг: **"гэртээ номгүй айл хөөрхий"** гэснээс үзвэл гэртээ номгүй хүн, гавалдаа юмгүй, аягүй бол "сум"-тай байж мэдэх гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Ном уншдаг хүн дэлхийгээр сэтгэдэг, уншдаггүй хүн **"дэнж"**-ээрээ сэтгэдэг болохоор **НОМ** бол Ц.Дамдинсүрэн гуайн хэлсэнчлэн: Өндөр ууланд шат шүү, өргөн далайд сал шүү, харанхуй мунхагт зул шүү, харгүй замд газарч шүү, бөглүү замд хүнс шүү, бүгд газар хөтөч шүү, ядрахад үл орхих янаг шүү, ямарч үед алдагдахгүй эрдэнэ шүү.

"Өдөр цаг бүхэн өлзий буян, од, гараг бүхэн онцгой сайн, муу сэтгэлээ ялагч бүхэн зовлонгүй, мунхгийн нойроос сэрэгч бүхэн чадал төгөлдөр" гэж Будда сургасан нь **"Найман гэгээн"** сударт дурайн үлджээ.

Чой Ла Жав Сү Чий-Номын авралд итгэе.